

## ДУНДАД ҮЕИЙН ИРАНЫ ШАГЛАА ЗУРАГТ МОНГОЛЧУУДЫН АМЬДРАЛЫН СЭДЭВ ЗОНХИЛСОН НЬ

Ц. Эрдэнэцог

*МУБИС, Дүрслэх урлаг технологийн сургууль*

### Резюме

В статье рассматриваются некоторые особенности картинов Персидские миниатюры -XV вв. В которых отразились образы монголов. В этих изображениях точно показан внешний вид и одежда персонажей, этнографически достоверно переданы предметы, различные церемонии и проч Монголов.

Цветовой строй персидской миниатюры имеет свои особенности – подчеркнутую орнаментальность, декоративность и яркость. Произведения художников при дворце Монгольских Иль ханов Восточной Азии со своейобразным элементом композиции, изображения и цветового сочетания внесли новую особенность манеры в развитии живописи центральной и Восточной Азии. К этой эпохе можно отнести “Живопись Персидско - Монгольского живопись” периода государства Иль хана монголии в Восточной Азии.

### Түлхүүр үг:

Монгол Их хаадын дур талын нүүдэлчдийн аж амьдрал, “Перс- Монгол уран зураг”.

XI-XIV зуунд Дундад болон Дорнод Азид эзэн суусан Монгол Иль хаант улсын хаад, хэсэг түүхч мэргэдэд Их хаадын амьдрал, тэдний ертөнцийг байлдан дагуулсан түүхийг өгүүлсэн зохиол бичих зарлиг буулгасан байна. Ингэж Жүвэйн зохиол “Ертөнцийг байлдан дагуулагчдын түүх”, Рашид-Ад-Дины “Судрын чуулган” болон “Төмөр хааны ялалтын судар” зэрэг зохиолууд гарчээ. Зохиогчид Монгол сурвалж бичгүүдийг голчлон хэрэглэж зохиолоо бичсэн байна. Жишээ нь: Рашид-Ад-Дин “Монгол он дарааллын бичиг, тэмдгүүд”, “Алтан Дэвтэр”, “Монгол хэлээр монгол бичгээр бичсэн боловч эмх цэгцтэй болгон цуглуулаагүй түүхэнд байгаа зүйлийг өргөн ашигласан тухайгаа номондоо олон удаа дурдсан байна. Түүнчлэн их ноён Болд Чинсан монголчуудын түүхийг мэдэх талаар их мэдлэгтэй хүн байсан бөгөөд тэр нь ертөнцийн түүх зохиох хааны комиссыг толгойлж байсан болохыг эрдэмтэд зохиолдоо тэмдэглэсэн байдаг.

Энэ түүхэн сурвалж зохиолыг бүтээхэд мөн зураг, чимэглэл онцлох үүрэгтэйг тунгаан үзсэнээр Персийн номын зураачдаас гадна хятад, дорно дахины авьяаслаг зураачдыг оролцуулсан буюу мөн Монгол зураачид онцлох үүрэг гүйцэтгэсэн болох нь түүхэн баримтаар нотлогдож байна. Үүний нэг нотолгоо нь, XIV зууны үед Иранд тогтсон Монголын Иль хаадын улсад Перс түүхч Рашид-ад-Дины удирдан зохиосон “Судрын чуулган” зохиолын чимэглэл зургийг бүтээлгэхээр хорь гаруй өрх Монгол, түрэг зураач урчуудыг илгээн ажиллуулж байсан баримт байгааг эрдэмтэн Д. Баяр зохиолдоо дурдсан байдаг.

Оросын эрдэмтэн М.В. Горелик “Ираны миниатюр зурагт XIV зууны хоёрдугаар хагасыг хүртлэх үеийн Монголчуудын хувцас, эд өлгийн соёлыг бодит үнэмшилтэй тусгасан” гэж үнэлжээ. Мөн эрдэмтэн Н.В. Пигулевская “Дундад зууны Монгол хаад, хятад болон нүүдэлчин ард, цэргүүдийн хувцас, эд хэрэглэлийн онцлогийг шаглаа зурагт тодорхой харуулсан нь тэр үеийн Монголчуудын ахуйн соёлыг судлаж мэдэхэд үнэтэй их баримт” болохыг үнэлж дүгнэжээ. Монголчуудын дүр байдал хувцас, эд хэрэглэлийг зөв ёсоор нь зурж, түүнчлэн талын нүүдэлчдийн аж амьдрал монгол цэргийн бусдаас ялгарах онцгой шинжийг гаргасан дүр бүтээхэд жинхэнэ Монгол зураач Иль хаадын ном бүтээх үйлсэд нэн шаардлагатай болсон буй заа. Судрын чимэг зургаас үзэхэд Монгол цэргийн хот, сууринг бүслэн хаах үеэс хэрэм эвдэх оньс, төмөр тэрэг, сум, жад, галт сум харвах оньс зэрэг монгол цэргийн зэр зэвсгийг зурагт тодорхой харуулсан байдаг. Мөн талын нүүдэлчдийн

хувцас, ахуйн эд хэрэглэл, уналга, тэдний донж байдлыг тун үнэмшилтэй илэрхийлсэн нь чухамдаа харийн зураачийн судалж байж зурсан зураг гэхээс энэ амьдралыг өөрөө туулж буй жинхэнэ монгол зураач байх нь дамжиггүй. Персийн шаглаа зургийн зохиомж, өнгө, дүрслэлийг судлаж үзэхэд зурлагын үндсэн хоёр өөр арга барил хөгжиж байжээ.

Персийн миниатюр зургийн уламжлал дээр үндэслэж Монгол ахуйг гаргасан зураг. Энэ төрлийн зураг цэцэг, навч, хээ хуараар гоёсон, хөх, шар, улаан, ногоон үндсэн өнгө болон цагаан, хар өнгө хосолж алтаар зурааслан чимсэн чимэглэлийн хэллэг илүүтэй зонхилсон зураг юм. Оросын эрдэмтэн Б.В. Вермарин “Хээлэг зурлага, хурц өнгө зохирол нь Персийн миниатюр

1. **Монгол цэргүүд цайзыг эзэлсэн нь** зургийн уламжлалт хэлбэр бөгөөд, цэцэглэж буй мод, ногоон навчис, эрэн Хивс салхины аясаар мушгиралдан буй үүлсийн дүрслэлээр баяжиж улам ч хурц, эрэн болдог гэж онцлон тэмдэглэсэн бөгөөд энэ арга барилаар зурсан зураг жинхэнэ Ираны миниатюр зургийн сургууль юм. Энэ барилын бүтээлүүдэд Монгол хаадын удмаас гаралтай Дундад Азийн Эмирийн аж амьдралаас сэдэвтэй зураг арвин байдаг.

Өөр нэг чиглэл нь цайвар шаргал дэвсгэрт дээр үйл явдлыг дэлгэмэл байдлаар дүрслэн зохиомжилж, цагаан, улаан, шар, хөх, бор, хүрэн өнгийн зохиролыг хослуулсан зураг юм. Эдгээр зурагт ногоон өнгийг тун бага хэрэглэсэн байдаг нь анзаарууштай. Харин аль болох энгийн бодит



илэрхийллийг эрхэмлэснээрээ онцлог бөгөөд энэ Хэлбэрийн зургийг жинхэнэ Монгол уламжлалт зургийн арга илэрхийллийг хадгалсан уран зураг гэж үзэх нь зүйтэй болов уу. Хэрвээ Иль хаадын зарлигаар Монгол газар орноос зориуд нилээд тооны зураачдыг авчирч судар номын зургийн үйлсэд дайчилж байсан бол энэ монгол зураачид уламжлалт зургийн арга барилыг түшиглэн зурж мөн Монгол зургийн арга барил бусад улсын зураачдын бүтээлд тусгалаа олж хөгжиж байсан нь шаглаа зургийн бүтээлүүдэд харагддаг.

Сударын зураачид Хааны зарлигийг биелүүлж байгаа тул бүтээл дээрээ нэрээ бичиж үлдээх эрх байгаагүй тул тухайн бүтээлийн зураачийг мэдэх бололцоо тун бага юм. Тэр бүтээл чухам ямар сургуулийн зураг болохыг уг бүтээлийн ажиллагаа, өнгө, дүрслэлээс мөшгөн судлах арга эрдэмтдэд оногдсон болно.

Эрдэмтэн, зураач Н. Цүлтэм “XIII – XIV хамт

зуунд Ираны номын зурагт Монгол хүний дүр, төрх, байдлыг их амьд, үнэмшилтэй зурсан байдаг буюу энэ бүтээлүүд нь Перс- Монгол уран зураг юм“ гэж тэмдэглэсэн байдаг. Эрдэмтэн С. Бадрал мөн Рашид-ад Дины “Судрын чуулган” номын зургууд нь Монгол зургийн нарийн зураас, хар хөх, улаан, шаргал өнгүүдээр Энгийн байдлаар бүтээгдсэн <...> Монголчуудын эрт үеийн амьдралыг номын санаагаар тодруулах байдлаар зурж.



**2. Монгол Иль хаан, түүний хатанд хүндэтгэл үзүүлж буй нь чимэглэсэн уран зураг болохыг мөн онцлон тэмдэглэсэнтэй санал нэг байна.**

Тэр үед Чингис хаан их асрын голд хатад, хөвгүүд, баатруудынхаа дунд хамтаа хүүрнэлдэн хөгжиж байгаа болон, Хүлэг хаан, Шабин хан, Газан уан, Улэгбек хан, Төмөр хан болон монгол гарлын Эмир ноёдын хөргийг үйл өрнөлөөр зохиомжлон зурах сэдэв судрын зурагт зонхилж байжээ. Энэ зургуудын зохиомж, дүрслэлийн онцлогоос тодотговол: “Чингис хаан ба хөгжимчин бүсгүй” хэмээх нэгэн зурагт Чингис хаан хөгжимчин

бүсгүйн тоглох ятгын аялгууг сонсох зуур төлөгч өвгөнөөр мэргэлүүлж буй зураг байдаг. Тансаг сайхан цэцэрлэгт хүрээлэнд үнэт эрээн хивсэн дээр тухлан суусан их хаан төлөгч өвгөний ийш тийш хаялах савхан модыг анхааралтай ширтэж байгаа байдлыг уг зурагт харуулжээ. Энэ зураг нилээд зохиомол шийдэлтэй бөгөөд их хааны ихэмсэг байдлыг илэрхийлэх нь гол зорилго байжээ.

Харин Хаан Улугбек бүтээлд хааны дүрийг үнэн бодитойгоор түүхэнд зурж үлдээх зорилго агуулсан нь тодорхой байдаг. Энэ зурагт Хаан Улугбек үнэт Чулуун шигтгээтэй хар үр цагаан нэхий малгай өмсөж хөх торгон дээл дээр угалз, хээ товойлгож чимсэн бүс бүсэлж, дэл эрээн хивсэн дээр завилан суусан байдлаар зуржээ. Мөн бусад албат түшмэл нар хар эмжээр овгор цагаан малгайтай, богиновтор ханцуйтай, зүүн тийшээ ташуу энгэртэй урт дээл дээр тийм ч өргөн биш бүс бүсэлсэн байгаагаар зурсан байдаг. Энэ бүтээлийг ажиглахад хээлэг нарийн зурлага, хурц эрээн өнгө зохицол илүүтэй зонхилсон байна.

Г.А.Пугаченкова “Ираны миниатюр зурагт үндсэн



**3. Цайзыг сэтэлсэн нь XV зуун. таван онгоулаан, ногоон, хар, цагаан, цэнхэр өнгийн ялгамж зонхилдог болохыг онцлон тэмдэглэсэн бөгөөд энэ зураг Ираны Миниатюр зургийн уламжлалт аргыг илэрхийлсэн зураг юм.**

Дээрхи зургуудаас ажиглахад хэдийгээр Монгол хаан, дээдсүүдийн дүр, үйл явдлын төвд дүрсэлсэн ч түүнийг тойрон хүрээлэн буй бусад дүрүүд Монгол ноёд хатдаас гадна, Узбек, Ираны ноёд, түшмэд, хатадын дунд өрнөж байна. Тэдгээр төлөөлөгчид нилээд монголжуу дүртэй байх буюу хувцас, эд хэрэглэлд

нь Монгол хийц түгээмэл харагддаг. Дундад зууны үед Монгол хатдын дунд түгээмэл дэлгэрсэн “бортого” малгай, хаад ноёдын өдөөр чимсэн хар бараан хүрээтэй эсгий эсвэл үнэт торгон гадартай малгай, ташуу энгэртэй, богино ханцуйтай дээл зэрэг нь энэ зургуудад түгээмэл зурагджээ. Мөн цэрэг, анчид, жирийн ардын ахуй байдал үйл өрнөл, тэдний унасан морь, Тэмээ зэрэг нь ихэд донжтой үнэмшилтэй байх нь чухам монгол зураач монголчуудын ахуй амьдралыг ийм үнэмшилтэй зурсан байх нь тодорхой юм. Эрдэмтэн Б.В. Вермарин XI – XIV зуунд Монгол - Татарын үед миниатюр зурагт Хятадын зургийн стиль нөлөөлсөн болохыг судалгаандаа мөн тодруулсан байна.

Зарим уран зурагт гол баатруудын дүр байдал морь, амьтны донж галбир зэрэг нь дундад улсын зургийн маягийг шингээсэн байдаг нь харагддаг.



#### 4. Монгол ноёны зугаалга XV зуун

Эндээс дүгнэхэд Персийн шаглаа зурагт Төв Азийн эзлэгдсэн орнуудаас авчирсан зураач урчууд түүхэн сурвалж бүтээлийн чимэглэл зурагт их зүтгэлтэй оролцож байсныг илтгэнэ.

Т.В. Грек энэ бүтээлүүдэд ихэнхдээ феодалын ангийн сонирхолд нийцсэн зөөлөн алтан зурааслал саарал фон дээр зурсан уран зураг хэмээн тэмдэглэсэн байх бөгөөд энэ барил нь дундад зууны Төв Азийн уран таалал мөн Юан улсын зургийн тогтсон үед зурсан Монгол хаад, хатдын хөрөг, аж

байдлын сэдэвт бүтээлүүд ч нотолно. Харин Рашид-Ад-Дины судрын чимэг зураг элдэв хээ чимэглэлээр бага, энгийн бодит үнэн байдлыг илүүтэй онцолсноороо өвөрмөц юм.



#### 5. Хаадын ордонд өрнөж буй амьдрал XIV—XV зуун

Дээр дурдсныг нэгтгэн дүгнэхэд: Дундад эртний монгол зураачид ихэс дээдсийнхээ хөрөг зураг, ахуй амьдралаас сэдэвлэсэн уран зураг бүтээх уламжлалтай байсан бөгөөд энэ чиглэлээр мэргэшсэн зураачид төрөн гарч эртнээс уламжлалт уран зургийн өнгө, дүрслэлийг хадгалан хөгжүүлсэн жинхэнэ

монгол зургийн сургуулийн арга маягийг тогтоосныг шаглаа зурагт тусгасан энгийн бодит илэрхийлэл, өгүүлэмжит зохиомж, цайвар шаргал дэвсгэрт дээрх ханасан тод өнгө зохиролт бүхий зургийн хэллэг харуулж байна.

Персийн номын зурагт Нэгд: Ираны зураачдын зурсан Хээлэг зурлагатай, эрээн тод өнгийн зохиролтой шаглаа зургийн арга.

Хоёрт: Дундад улсын уламжлалт зураг болох Монотоны (хэсэгхэн өнгө) зонхилсон уусгалт уран зургийн арга хэлбэр.

Гуравт: Монгол зургийн уламжлалыг хадгалсан дэлгэмэл зохиомжтой, ханасан тод өнгийн Зохиролтой уран зураг буюу үндсэн гурван урсгал зонхилж байсан гэж үзэх үндэслэлтэй.

Персийн шаглаа зургийн Монгол Их хаадын дүр, талын нүүдэлчдийн аж амьдрал, цэргийн үйл хэргийг тусгасан сэдэвт зургийг зурахад Төв Азийн нүүдэлчдийн дундаас гаралтай “Монгол” зураачид ихээхэн үүрэг гүйцэтгэж байсан нь түүхэн баримт, уран бүтээлийн арга илэрхийллээр Тодорч байгаа бөгөөд энэ үеийн уран зургийг XIII — XIV зууны Ираны номын зурагт хөгжсөн “Перс-Монгол уран зураг” хэмээн нэрлэж урлагийн түүхэнд үечлэн авч гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй юм.

**Зүүлт тайлбар:**

- Цэрэндорж Г. XIII-XIV зууны үеийн монголын соёл // Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Түүх. - Ред Ш. Бира. УБ., 1984. - Х. 184.
- Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Түүх... Х. 184.
- Баяр Д. Эзэн Богдын эх хөрөг.-УБ., 1997. – Х. 14.
- Горелик М.В. Монголы и тебризской миниатюре XIV — XV веков доклад // всесоюзного научной конференции. Ч.1. – М., 1983. – Ч.1. – С. 69.
- Пигулевская Н.В. и др. История Ирана с древнейших времен до конца XVII века. – Л., 1958.
- Gerhard Schroder Dschingis Khan und seine erben. Das weltlich Der Mongo — Hirmer 2005. 1-р зураг уг номын — Р. — 280 т буй Inthronisation eines mongolischen Herrschers. - Tabris (?) Iran, 14. Jh. - Wasswerfarben auf Papierrechts: H 34,7 cm; b 28,3 cm; Links: h 38,8 cm, b 29,2 cm; 2 - р зураг уг номын Р. 290 т буй, хэмжээ мөн ижил.
- Вермарин Б.В. Искусство Арабских стран и Ирана. – М., 1974. – С. 104.
- Цултэм Н. Искусство Монголии - УБ., 1986. – С. 45.
- Бадрал С. “Түүхийн чуулган” буюу Дашид-ад-Дины ном, зураг чимэглэлийн тухайд // Чингис хаан судлал эрдэм шинжилгээний бичиг XV дэвтэр. — УБ., 2005. – Х. 58.
- Мухаммад — Тарагай Улугбек внука Тимура, сына Шахруха и Гауруха и Шад. Его дед Тимур происходил из монгольского в своей основе, но отуреченного по крови и по языку рода Барласов. См.: Пугаченкова Г.А. Портрет Улугбека (проблема миниатюрной живописи тимуридского Самарканда) // Народы Азии и Африки. – М., 1969, №6. – С. 98.
- См.: Пугаченкова Г.А. Искусство Афганистана. – М., 1963. - С.223.
- Вейрмарин Б.В. Из истории мирового искусства: Искусство Арабских стран и Ирана VII-XVII веков. – М., 1974. – С.123.
- Горелик М.В. Монголы и тебризской миниатюре XIV — XV веков... - С. 69.